



МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

2014 ОНЫ 2-Р УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

ОНЦЛОХ МЭДЭЭ:

- 2014 оны эхний хагас жилд урсгал тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 дахин буурлаа.
- Монгол Улсын гадагш хийсэн хөрөнгө оруулалтын үлдэгдэл буурч байхад гадаадаас Монголд оруулсан хөрөнгө оруулалтын үлдэгдэл нэмэгдсэн нь хөрөнгө оруулалтын богино позиц нэмэгдэхэд нөлөөлжээ.
- Монгол Улсын нийт гадаад зээлийн үлдэгдэл 19.8 тэрбум ам.долларт байна.

АГУУЛГА

Төлбөрийн тэнцэл	2
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	4
Нийт гадаад зээл	5
Хавсралт	6

Валют, эдийн засгийн газрын Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтэс

Монголбанк
Бага тойруу 3,
Улаанбаатар 15160
Утас: 976-11-323243,
327086, 327088

Факс: +976-11-327088
Email:
bor@mongolbank.mn

Төлбөрийн тэнцэл (BOP)

2014 оны 2-р улиралд (4-6 сарууд) урсгал данс 474.1 сая ам.долларын, хөрөнгө ба санхүүгийн данс 254.7 сая долларын алдагдалтай, алдаа ба орхигдуулга – 121.4 сая ам.доллар гарснаар, төлбөрийн нийт тэнцэл –607.3 сая ам.доллар болж, гадаад валютын албан нөөц уг дүнгээр өөрчлөгдлөө.

2013 оны 2-р улиралтай харьцуулахад урсгал дансны алдагдал 362.0 сая ам.доллараар, хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг 511.8 сая ам.доллараар тус тус буурсан байна.

Хөрөнгө, санхүүгийн дансыг бүтцээр нь авч үзвэл ШХО 56%-иар буюу 224.3 сая ам.доллараар буурсан бол багцын ХО 23.1 сая ам.доллараар өсч, бусад ХО –ын алдагдал 312.2 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаадад байршуулсан санхүүгийн хөрөнгө (актив) 3,135.8 сая ам.доллар, гадаадад төлөх санхүүгийн өглөг (пассив) 25,921.6 сая ам.долларт тус тус хүрснээр гадаад хөрөнгө оруулалтын позиц улирлын эцэст 22,785.8 сая ам.долларын сөрөг үлдэгдэл буюу богино байна. Энэ нь Монгол Улс цэвэр дүнгээр гадаадад төлөх санхүүгийн өглөгтэй болохыг харуулж байгаа бөгөөд богино позиц нь өнгөрсөн оны мөн үеэс 28% буюу 5.0 тэрбум ам.доллараар нэмэгдсэн.

Үүнд: ШХО-ийн богино позиц 1.9 тэрбум ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэр 1.5 тэрбум ам.доллараар өсч, ГВУН 1.8 тэрбум ам.доллараар буурсан нь нөлөөлжээ.

Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2014 оны 2-р улирлын гүйцэтгэлээр 19,826.9 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 14%-иар буюу 2,437.4 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Үүнд: Засгийн газар болон Төв банкны гадаад өр өнгөрсөн оны мөн үеэс 18%-иар буюу 835.7 сая ам.доллараар өсч 5,529 сая ам.долларт, хувийн хэвшлийн салбарын гадаад өр 13%-иар буюу 1,601.7 сая ам.доллараар нэмэгдэн 14,297.9 сая ам.долларт хүрээд байна.

Гадаад секторын статистик гэж юу вэ?


Гадаад секторын статистик гэж аливаа улс орны гадаад ертөнцтэй харилцах эдийн засгийн харилцааг үзүүлэгч эдийн засгийн төлбөр тооцооны дансдын урсгал болон үлдэгдлийн мөнгөн үзүүлэлтийг хэлдэг.

Энэхүү үзүүлэлтэд төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад зээл, гадаад валютын улсын нөөцийн мэдээ зэрэг статистик мэдээллүүд багтдаг.


Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл




Дүрслэл 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц



Дүрслэл 3. Нийт гадаад өрийн үлдэгдэл



Дүрслэл 4. Статистик хамаарал



I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

УРСГАЛ ДАНС

Тайлант улиралд урсгал тэнцлийн алдагдал 474.1 сая ам.доллар гарч, алдагдлын хэмжээ 2013 оны мөн үеэс 43%-иар буурчээ.

Бараа, үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 400.7 сая ам.доллараар буурсан нь барааны алдагдал 416.2 ам.доллараар буурч 5.6 сая ам.долларын ашигтай гарсантай холбоотой байна.

Барааны худалдаа

Төлбөрийн тэнцэл дэх барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5%-иар өсч 2,982.2 сая ам.долларт хүрсэн. Барааны худалдааны тэнцэл тайлант хугацаанд эерэг тэмдэгтэй 5.6 сая ам.долларт хүрч, 2 сар дараалан ашигтай гарлаа.

Барааны худалдааны тэнцэл сайжрахад зэсийн баяжмал, боловсруулаагүй нефтийн экспортын өсөлт болон хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, бүх төрлийн автомашин, нефтийн бүтээгдэхүүний импортын бууралт зэрэг нь голлон нөлөөлсөн.

Үйлчилгээний худалдаа

Тайлант улирлын үйлчилгээний орлого өнгөрсөн оны 2 дугаар улиралтай харьцуулахад 16%-иар буурч 157 сая ам.доллар, зарлага нь 3%-иар буурч 519 сая ам.доллар болсноор алдагдал 4%-иар өсч 362 сая ам.долларт хүрсэн байна.

Алдагдал ийнхүү өсөхөд бусад үйлчилгээний зардал 45%-иар буюу 73 сая ам.доллараар өссөн бөгөөд үүнд бизнесийн удирдлагын зөвлөх үйлчилгээний зардал 74 сая ам.доллараар өсч 81 сая ам.доллар болсон нь голчлон нөлөөлжээ.

Харин импортын бууралтаас шалтгаалан тээврийн үйлчилгээний зарлага өнгөрсөн оны мөн үеэс 27%-иар буурч 196 сая ам.долларт хүрсэн байна.

Орлого

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагуудаас харьяат бус хувьцаа эзэмшигчиддээ 11.9 сая ам.долларын ноогдол ашгийг хуваарилж, гадны хөрөнгө оруулагчдаасаа авсан зээлийн эх үүсвэрт 118.6 сая ам.долларын хүү төлсөн бол Монгол Улсын Засгийн газар гадаадаас авсан зээлийн эх үүсвэрийн хүүгийн төлбөрт 4.5 сая ам.доллар, банкууд эдийн засгийн харьяат бусийн харилцах, хадгаламжийн эх үүсвэрт 17.1 сая ам.долларын хүүг тус тус төлжээ.


Монгол Улсад ажиллаж буй гадаад ажилтнуудад олгосон цалин хөлсний хэмжээ 34.6 сая ам.долларт хүрснээс шалтгаалж ажиллагсдын цалин хөлсний данс цэвэр дүнгээр 20.8 сая ам.долларын алдагдалтай гарсан нь 2013 оны мөн үеэс 70%-иар буурсан үзүүлэлт юм.

Хөрөнгө оруулалтын орлогын данс 151.6 сая ам.долларын алдагдалтай гарч 2013 оны мөн үетэй харьцуулахад алдагдлын хэмжээ 3.7 дахин өсөв. Улмаар цэвэр орлогын дансны алдагдал тайлант хугацаанд 172.4 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 57%-иар өссөн байна.

Урсгал шилжүүлэг

Гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын дүн өмнөх оны мөн үеэс 21%-иар өссөн бол гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 15%-иар буурсан байна. Ингэснээр ажилчдын гуйвуулга цэвэр дүнгээр 16.8 сая ам.доллараар өсчээ.

Хүснэгт 1. Урсгал тэнцэл (сая \$)					
Үзүүлэлт	2-р улирал		Өөрчлөлт		
	2013	2014	Дүн	Хувь	
I. Урсгал тэнцэл	-836.1	-474.1	-362.0	-43%	
A. Бараа, үйлчилгээний худалдаа	-757.3	-356.6	-400.7	-53%	
а. Бараа	-410.5	5.6	-416.2	-101%	
б. Үйлчилгээ	-346.7	-362.2	15.5	4%	
Б. Цэвэр орлого	-110.1	-172.4	62.3	57%	
В. Урсгал шилжүүлэг	31.3	54.9	23.6	76%	



Хүснэгт 2. Ажилчдын гуйвуулга, (улсаар, мянган ам.доллар)						
	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	13 346	23%	▲ 30%	3 192	8%	▼ -30%
Америк	6 077	11%	▲ 19%	7 019	17%	▲ 4%
Хятад	3 685	6%	▼ -10%	9 019	22%	▼ -8%
Гонг Конг	1 911	3%	▼ -27%	363	1%	▼ -72%
Англи	4 128	7%	▲ 35%	1 262	3%	▼ -15%
ОХУ	2 148	4%	▲ 22%	3 674	9%	▲ 68%
Сингапур	1 384	2%	▼ -32%	1 299	3%	▼ -55%
Швейцарь	1 934	3%	▲ 5%	326	1%	▲ 5%
Герман	2 126	4%	▲ 1%	869	2%	▲ 16%
Япон	1 716	3%	▲ 0%	1 553	4%	▲ 24%
Бусад	18 818	33%	▲ 47%	11 872	29%	▼ -28%
НИЙТ	57 273	100%		40 449	100%	

Хүснэгт 3. Ажилчдын гуйвуулга, (I улирал, сая \$)					
	2012	2013	2014	Жилийн өөрчлөлт	
				Мөнгөн дүн	Хувиар
Ажилчдын гуйвуулга (цэвэр)	9,6	-0,3	16,8	17,1	-5310%
Гаднаас орж ирсэн	66,4	47,3	57,3	9,9	21%
Гадагш шилжүүлсэн	-56,8	-47,6	-40,4	7,20	-15%

I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ДАНС

Тайлант улиралд хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 254.7 сая ам.долларын алдагдалтай гарч өнгөрсөн оны мөн үеэс -511.8 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Тайлант хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 175.4 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 56%-иар буюу 224.3 сая ам.доллараар буурчээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралтыг данс тус бүрээр нь авч үзвэл:

1. Дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2%-иар буурч, 118.4 сая ам.долларт;
2. Компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилготой зээлийн эх үүсвэрийн санхүүжилт 72%-иар буурч, 129.2 сая ам.долларт тус тус хүрсэн байна.

Тайлант хугацаанд орж ирсэн Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт эх үүсвэрийн 33% нь БНХАУ-аас, 19% нь Гонг Конгийн хөрөнгийн бирж, банк, санхүүгийн байгууллагаар дамжин санхүүжигдсэн байна. БНХАУ-аас хийгдсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4%-иар буурсан бол, Гонг Конгоос хийгдсэн хөрөнгө оруулалт 88%-иар буурчээ.

Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс тайлант хугацаанд 4.6 сая ам.доллар гарахад:

(I) манай иргэд, аж ахуйн нэгжүүд гадны хуулийн этгээдийн хувьцаа, үнэт цаасыг худалдаж авахад 9.6 сая ам.долларыг зарцуулсан,

(II) гадны иргэд, аж ахуйн нэгжүүд эдийн засгийн харьяатын хөрөнгийн хувьцааг худалдаж авахад 8.1 сая ам.долларыг төлж (орох урсгал), бонд, үнэт цаасыг 6.1 сая ам.доллараар худалдаж авснаар (орох урсгал) пассив 14.2 сая ам.долларт хүрсэн нь нөлөөлсөн байна.

Бусад хөрөнгө оруулалт

Тайлант улиралд бусад хөрөнгө оруулалтын данс 463.4 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 312.2 сая ам.доллараар өсчээ.

Энэ нь манай улсын эдийн засгийн харъяат банк, аж ахуйн нэгж, иргэдийн гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн цэвэр урсгал -83.2 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 299.0 сая ам.доллараар буурснаас голчлон шалтгаалжээ.

Алдаа ба орхигдуулга


Тайлант хугацаанд алдаа ба орхигдуулга үзүүлэлт 121.4 сая ам.доллар гарч, өмнөх оны мөн үеэс 127.9 сая ам.доллараар өссөн байна.

Түүнчлэн уг үзүүлэлт эерэг дүнтэй гарсан нь тайлант хугацаанд дотогш чиглэсэн хөрөнгийн урсгал буюу гадаадаас хүлээн авсан төлбөр тооцоо дутуу бүртгэгдэж байж болзошгүйг харуулж байна.


Хүснэгт 4. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл (сая \$)				
Үзүүлэлт	2-р улирал		Өөрчлөлт	
	2013	2014	Дүн	Хувь
II. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл	257.1	-254.7	-511.8	-199%
А. Хөрөнгийн данс	27.2	28.8	1.7	6%
Б. Санхүүгийн данс	229.9	-283.5	-513.4	-223%
а. Шууд хөрөнгө оруулалт	399.7	175.4	-224.3	-56%
Гадагш хийсэн	-14.4	-10.2	-4.2	-29%
Монгол Улсад орсон	414.0	185.6	-228.5	-55%
б. Багцын хөрөнгө оруулалт	-18.5	4.6	23.1	-125%
в. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0.0	-0.1	-0.1	
г. Бусад хөрөнгө оруулалт	-151.2	-463.4	312.2	206%
Үүнээс: Худалдааны зээл	-10.7	-85.5	74.8	699%
Бэлэн мөнгө харилцах	-356.3	-299.7	-56.6	-16%

Хүснэгт 5. Монгол улсад орсон ШХО (сая \$)				
Үзүүлэлт	2014 он 2-р улирал		2014Q2/2013Q2	
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өөрчлөлт %	
БНХАУ	82.6	33%	-4%	▼
Өмнөд Солонгос	20.0	8%	51%	▲
Канад	6.2	2%	-7%	▼
Гонг Конг	47.8	19%	-88%	▼
Япон	19.3	8%	-13%	▼
ОХУ	0.5	0%	-31%	▼
Англи	1.9	1%	-73%	▼
АНУ	10.2	4%	-71%	▼
Европ тив (Англи, ХБНГУ-аас бусад)	0.9	0%	-7%	▼
Австрали	4.6	2%	-85%	▼
ХБНГУ	1.9	1%	-41%	▼
Сингапур	20.3	8%	391%	▲
Бусад	31.7	13%		
Орлогын дахин хөрөнгө оруулалт	-62.1	-		
Нийт	185.6	100%		

Дүрслэл 7. Бусад хөрөнгө оруулалт (сая \$)



Дүрслэл 8. Улсын гадаад валютын цэвэр албан нөөц



II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2014 оны 2-р улирлын эцэст –22,785.8 сая ам.доллар байв.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 22.8 тэрбум ам.доллараар их байна. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын болон бусад хөрөнгө оруулалт, ялангуяа улсын өрийн үлдэгдлээс голлон хамаарч байна.

Монгол Улсаас эдийн засгийн харьяат буст оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 3,135.8 сая ам.доллар байна. Үүний 42%-ийг гадаад валютын албан нөөц, 40%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 9%-ийг багцын хөрөнгө оруулалт, үлдсэн 8%-ийг шууд хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 25,921.6 сая ам.долларт хүрчээ. Үүний 64%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 25%-ийг бусад хөрөнгө оруулалтын пассив, үлдсэн 11%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 36%-ийг буюу 6,003 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 64% буюу 10,674.5 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 28%-иар буюу 5,033.7 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнийг:

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 32%-иар буюу 1,506.8 сая ам.доллараар буурч, гадаад пассив 16%-иар буюу 3,526.9 сая ам.доллараар нэмэгдсэнээр,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 13%-иар буюу 1,943.6 сая ам.доллараар өсч, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 26%-иар буюу 1,050.6 сая ам.доллараар буурсанаар,
- Өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, гадаад хөрөнгө оруулалтын богино позиц тайлант улиралд өмнөх улирлаас төлбөрийн тэнцлийн орох, гарах урсгалаар 323.8 сая ам.доллар, ханшийн зөрүүгээр 35.6 сая ам.доллараар өсч, үнийн өөрчлөлтөөр 26.3 сая ам.доллар болон бусад өөрчлөлтөөр 352.3 сая ам.доллараар буурсанаар тайлбарлагдаж байна.

Хөрөнгийн зах зээлийн үнэ

Монгол Улсад хөрөнгө оруулсан, Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн хувьцааны үнэ 2014 оны 2-р улиралд өмнөх улирлын хаалтын ханштай харьцуулахад дунджаар 10%-иар буурчээ.

Дээрхээс 4 ААН-ийн хувьцааны үнэ голчлон буурсан байна. Үүнд Хонг Конгийн биржид бүртгэлтэй ММС 32.9%-иар, Пийс Мал Холдинг лимитед 23.1%-иар, Лондонгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Петро Матад 40.5%-иар, Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Харанга Ресурс 50.0%-иар тус тус буурчээ. Харин Сентерра гоулд компанийн хувьцаа хамгийн ихээр буюу 30.7%-иар өссөн байна.


Хүснэгт 7. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	6/30/2013	6/30/2014	Өөрчлөлт	
			Дүн	Дахин
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-17,752.1	-22,785.8	-5,033.7	1.3
I. Гадаад актив	4,642.6	3,135.8	-1,506.8	0.7
1. Шууд хөрөнгө оруулалт	209.1	265.5	56.4	1.3
2. Багцын хөрөнгө оруулалт	386.2	291.0	-95.2	0.8
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0.0	4.9	4.9	0.0
4. Бусад хөрөнгө оруулалт	939.8	1,256.8	317.0	1.3
5. Нөөц актив	3,107.5	1,317.5	-1,789.9	0.4
II. Гадаад пассив	22,394.7	25,921.6	3,526.9	1.2
1. Шууд хөрөнгө оруулалт	14,733.9	16,677.4	1,943.6	1.1
2. Багцын хөрөнгө оруулалт	2,665.2	2,876.1	210.9	1.1
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0.0	4.9	4.9	0.0
4. Бусад хөрөнгө оруулалт	4,995.6	6,363.1	1,367.5	1.3

Дүрслэл 9. Гадаад актив



Дүрслэл 10. Гадаад пассив



Хүснэгт 8. Олон улсын хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ

№	Компанийн нэр	Симбол	Бирж	Мөнгөн тэмдэгт	Хаалтын үнэ		Өөрчлөлт
					3/31/2014	6/30/2014	
1	Turquoise Hill Resources	TRQ:US	US	USD	3.33	3.34	0.3%
2	Mongolian Mining Corp	0975.HK	HK	HKD	0.73	0.49	-32.9%
3	Centerra Gold	CG.TO	CAD	CAD	5.15	6.73	30.7%
4	Southgobi Resources	1878.HK	HK	HKD	4.85	5.10	5.2%
5	Winsway Cocking Coal	1733.HK	HK	HKD	0.37	0.40	8.1%
6	Mongolia Energy Corp	0276.HK	HK	HKD	0.22	0.22	0.0%
7	Petro Matad	MATD.L	LN	GBP	4.62	2.75	-40.5%
8	Prophecy Coal Corp	PCY.TO	CAD	CAD	0.05	0.05	0.0%
9	Haranga resources	HAR.AX	AU	AUD	0.08	0.04	-50.0%
10	Peace Map Holding Limited	0402.HK	HK	HKD	0.26	0.20	-23.1%

III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2014 оны 2-р улирлын байдлаар 19.8 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 2.4 тэрбум ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнийг салбараар нь авч үзвэл:

Улсын салбар: Засгийн газар, Монголбанкны гадаад өр 835.7 сая ам.доллараар нэмэгдэж 5,529 сая ам.долларт хүрчээ.

Хувийн хэвшил: Банк, бусад сектор, хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн жилийн хугацаанд 1,601.7 сая ам.доллараар нэмэгдэж 14,297.8 сая ам.долларт хүрээд байна.

Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2014 оны 2-р улирлын байдлаар 1,458.5 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 20.3%-иар буюу 245.6 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 33%-ийг урт хугацаат зээл, 32%-ийг бонд, өрийн бичиг, 14%-ийг богино хугацаат зээл, 9%-ийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг, үлдсэн 11%-ийг бусад өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкууд тайлант улиралд гадаадын банк, санхүүгийн байгууллагаас 34.8 сая ам.долларын урт хугацаат, 26.1 сая ам.долларын богино хугацаат зээлийн шинээр авч, зээлийн гэрээнд заасан хуваарийн дагуу харгалзан 38.7 сая ам.доллар, 9.9 сая ам.долларын үндсэн төлбөрийг буцаан төлснөөр зээлийн үлдэгдэл 483.4 сая ам.доллар, 214.6 сая ам.долларт тус тус хүрчээ.

Банкны бус салбар

Банк бус салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2014 оны 2-р улирлын эцэст 12,839.3 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 20%-иар буюу 2,172.5 сая ам.доллараар нэмэгдсэн.

Салбарын нийт зээлийн 83% буюу 10,674.5 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчийн зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна. Эх үүсвэр нь компаний эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь үгүй, улмаар харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлээс ялгаатай юм.


Хөрөнгө оруулагчдын санхүүжилтийн ашиглалт болон буцаан төлөлтийн байдлыг үзвэл тайлант улиралд 318.4 сая ам.доллар, 189.2 сая ам.доллар тус тус байжээ.

ААНБ-уудын экспортын бараа, үйлчилгээнд авсан урьдчилгаа төлбөр болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын бараа үйлчилгээний урт, богино хугацаат өглөгийн үлдэгдэл тайлант улирлын байдлаар 548.7 сая ам.доллар болсон.


Хүснэгт 9. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	6/30/2013	6/30/2014	Өөрчлөлт	
			Дүн	Дахин
Нийт гадаад өр	17,389.5	19,826.9	2,437.4	1.1
I. Засгийн газар	4,212.1	4,488.7	276.6	1.1
II. Төв банк	481.2	1,040.3	559.1	2.2
III. Банк	1,212.9	1,458.5	245.7	1.2
Богино хугацаат	61.3	214.6	153.2	3.5
Урт хугацаат	1,151.5	1,244.0	92.4	1.1
IV. Бусад сектор	1,653.2	2,164.9	511.7	1.3
Богино хугацаат	457.3	457.0	-0.3	1.0
Урт хугацаат	1,195.9	1,707.9	512.0	1.4
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	9,830.1	10,674.5	844.4	1.1

Дүрслэл 11. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 12. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газрын гадаад өр: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: Монголбанк, ТТБГазар, ВЭЗГазар
3. Банк: Арилжааны банкуудын тайлан тэнцэл, Төлбөрийн тэнцлийн мэдээ, Гадаад зээлийн бүртгэл
4. Банк бус салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, Банкуудын гадаад гүйлгээний тайлан, Гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	2 дугаар улирал			Өөрчлөлт				Дундаж, сүүлийн		
	2012	2013	2014	Дүн	2013/12	Дүн	2014/13	3 сар	6 сар	9 сар
I. Урсгал Тэнцэл	-677	-836	-474	-159	24%	362	-43%	-175	-161	-192
A. Бараа ба үйлчилгээний худалдаа	-538	-757	-357	-219	41%	401	-53%	-147	-129	-152
1. Бараа	-253	-411	6	-157	62%	416	-101%	-17	-9	-35
1.1 Ерөнхий эд бараа	-275	-487	14	-213	77%	502	-103%	-20	-17	-51
Экспорт Ф.О.Б. (Кредит)	1,353	1,122	1,494	-231	-17%	372	33%	435	373	365
Үүнээс: Зэсийн	223	195	637	-28	-13%	442	227%	145	122	112
Импорт Ф.О.Б. (Дебит)	-1,627	-1,609	-1,480	18	-1%	129	-8%	-455	-390	-417
Үүнээс: Нефтийн	-282	-299	-298	-17	6%	2	-1%	-94	-102	-106
Хүнсний	-102	-115	-134	-12	12%	-19	17%	-34	-39	-40
1.2 Мөнгөжөөгүй алт	25	93	0	68	275%	-93	-100%	9	16	23
Кредит	25	93	0	68	275%	-93	-100%	9	16	23
Дебит	0	0	0	0	0%	0	0%	0	0	0
1.3 Бусад	-3	-16	-9	-12	363%	7	-46%	-6	-6	-2
Кредит	1	0	0	-1	-83%	0	-100%	0	0	0
Дебит	-5	-16	-9	-11	245%	8	-47%	-6	-8	-6
2. Үйлчилгээ	-285	-347	-362	-62	22%	-16	4%	-130	-120	-117
2.1 Тээвэр	-238	-204	-145	34	-14%	60	-29%	-47	-43	-46
Кредит	74	65	52	-9	-12%	-13	-20%	17	17	18
Дебит	-312	-269	-196	43	-14%	73	-27%	-64	-61	-65
2.2 Аялал	19	-55	-40	-74	-388%	15	-27%	-19	-22	-21
Кредит	108	44	44	-65	-60%	0	0%	10	8	10
Дебит	-89	-99	-84	-10	11%	14	-15%	-28	-30	-31
2.3 Бусад үйлчилгээ	-65	-88	-177	-22	34%	-90	102%	-64	-55	-49
Кредит	50	77	61	27	55%	-16	-21%	18	19	20
Дебит	-115	-165	-238	-50	43%	-73	45%	-82	-74	-70
B. Орлого	-226	-110	-172	116	-51%	-62	57%	-47	-50	-56
1. Ажиллагсдын цалин хөлс	-55	-69	-21	-13	24%	48	-70%	-6	-8	-9
Кредит	8	11	14	3	32%	3	29%	5	5	5
Дебит	-63	-79	-35	-16	25%	45	-56%	-11	-13	-14
2. Хөрөнгө оруулалтын орлого	-170	-41	-152	129	-76%	-110	266%	-41	-42	-47
Кредит	18	2	2	-16	-90%	0	-9%	1	0	0
Дебит	-188	-43	-153	145	-77%	-110	254%	-42	-42	-47
C. Урсгал шилжүүлэг (цэвэр)	87	31	55	-56	-64%	24	76%	18	18	16
Кредит	152	80	100	-71	-47%	19	24%	33	31	29
Дебит	-65	-49	-45	16	-24%	4	-9%	-14	-13	-14
Үүнээс: Ажиллагсдын гуйвуулга	10	0	17	-10	-103%	17	-5563%	7	6	6
Кредит	71	47	57	-24	-33%	10	21%	20	18	18
Дебит	-62	-48	-40	14	-23%	7	-15%	-13	-12	-12
0	0	0	0							
II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл	584	257	-255	-327	-56%	-512	-199%	-84	13	45
A. Хөрөнгийн данс	25	27	29	2	9%	2	6%	11	13	12
B. Санхүүгийн данс	559	230	-283	-329	-59%	-513	-223%	-95	1	33
1. Шууд хөрөнгө оруулалт	1,223	400	175	-823	-67%	-224	-56%	67	95	107
1.1 Гадагш хийсэн	-6	-14	-10	-9	145%	4	-29%	0	-1	-3
1.1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	-6	-9	-9	-3	56%	0	3%	0	-1	-3
1.1.2 Орлогын дахин хөрөнгө	0	0	0	0	0%	0	0%	0	0	0
1.1.3 Бусад хөрөнгө	0	-5	-1	-5	0%	4	0%	0	0	0
1.2 Монголд орсон	1,229	414	186	-815	-66%	-228	-55%	67	96	110
1.2.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	613	121	118	-492	-80%	-3	-2%	42	36	42
1.2.2 Орлогын дахин хөрөнгө	45	-174	-62	-219	-485%	112	-64%	-27	-29	-26
1.2.3 Бусад хөрөнгө	571	467	129	-104	-18%	-337	-72%	53	89	94
2. Багцын хөрөнгө оруулалт	27	-18	5	-45	-169%	23	-125%	-1	58	22
2.1 Актив	-3	0	-10	3	-86%	-9	1892%	-4	-5	-3
2.1.1 Хөрөнгийн хувьцаа	-3	0	-8	3	-86%	-7	1517%	-3	-2	-2
2.1.2 Өрийн бичиг	0	0	-2	0	-74x	-2	-12352%	-1	-3	-2
2.2 Пассив	30	-18	14	-48	-160%	32	-35x	3	63	26
2.2.1 Хөрөнгийн хувьцаа	18	3	8	-15	-83%	5	158%	3	2	1
2.2.2 Өрийн бичиг	12	-21	6	-33	-279%	27	-129%	0	61	25
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	0	0	0	0%	0	0%	-3	-2	-1
3.1 Актив	0	0	0	0	0%	0	0%	0	1	2
3.2 Пассив	0	0	0	0	0%	0	0%	0	0	0
4. Бусад хөрөнгө оруулалт	-691	-151	-463	539	-78%	-312	206%	-159	-150	-95
4.1 Актив	-786	-304	-320	482	-61%	-16	5%	-187	-186	-158
4.1.1 Худалдааны зээл	-6	67	-32	73	-1141%	-98	-148%	-28	-29	-28
4.1.2 Зээл	12	-3	-2	-14	-122%	0	-5%	0	0	0
4.1.3 Бэлэн мөнгө ба харилцах	-791	-368	-286	423	-53%	82	-22%	-159	-156	-131
4.1.4 Бусад актив	0	0	0	0	0%	0	0%	0	0	0
4.2 Пассив	95	153	-143	58	61%	-296	-194%	28	35	63
4.2.1 Худалдааны зээл	72	-77	-54	-150	-207%	24	-30%	0	10	12
4.2.2 Зээл	14	218	-81	205	1477%	-299	-137%	31	25	46
4.2.3 Бэлэн мөнгө ба харилцах	9	12	-14	3	32%	-26	-217%	-3	0	4
4.2.4 Бусад пассив	0	0	5	0	0%	5	0%	0	0	0
0	0	0	0							
III. Алдаа болон орхигдуулга	205	-6	121	-212	-103%	128	-1982%	35	16	17
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	112	-585	-607	-698		-22	4%	-225	-131	-129
0	0	0	0							
IV. Гадаад валютын цэвэр нөөцийн өөрчлөлт*	-112	585	607	698	-621%	22	4%	225	131	129
1. Актив	-112	609	631	721		22		225	131	129
1.1 Мөнгөжсөн алт	0	54	0	54		-54		0	7	4
1.2 Зээлжих тусгай эрх	2	0	0	-1		0		0	0	0
1.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө	0	0	0	0		0		0	0	0
1.4 Бэлэн валют ба харилцах	-93	555	631	648		76		225	124	125
1.5 Бусад нөөц актив	-21	0	0	21		0		0	0	0
2. Пассив	0	-23	-24	-23		0		0	0	0
2.1 ОУВС-ийн зээл	0	-23	-24	-23		0		0	0	0
2.2 Онцгой санхүүжилт	0	0	0	0		0		0	0	0

* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (мянган ам.доллар)

Үзүүлэлт	3/31/2012	6/30/2012	9/30/2012	12/31/2012	3/31/2013	6/30/2013	9/30/2013	12/31/2013	3/31/2014	6/30/2014
Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр)	-9,741,340.0	-11,308,480.7	-12,785,836.1	-14,219,393.4	-15,875,806.9	-17,752,062.6	-18,738,603.3	-19,856,790.8	-20,864,744.0	-22,785,796.8
I. Гадаад актив	5,674,551.6	5,051,386.8	5,118,273.1	6,380,073.0	5,547,653.3	4,642,634.1	4,465,062.4	4,005,060.3	3,910,589.3	3,135,786.0
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	1,691,482.0	1,060,506.9	1,082,122.6	1,191,414.3	194,345.3	209,141.3	215,325.4	257,722.3	259,203.2	265,542.2
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	1,691,482.0	1,060,406.6	1,081,319.4	1,190,611.2	193,542.1	203,840.9	210,755.0	252,016.0	253,023.3	258,402.3
1.1.1 Салбар компаниас авах	1,691,482.0	1,060,406.6	1,081,319.4	1,190,611.2	193,542.1	203,840.9	210,755.0	252,016.0	253,023.3	258,402.3
1.1.2 Салбар компанид өгөх (-)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.2 Бусад хөрөнгө	0.0	100.4	803.2	803.2	803.2	5,300.4	4,570.4	5,706.2	6,180.0	7,140.0
1.2.1 Салбар компаниас авах	0.0	100.4	803.2	803.2	803.2	5,300.4	4,570.4	5,706.2	6,180.0	7,140.0
1.2.2 Салбар компанид өгөх (-)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2. Багцын хөрөнгө оруулалт	28,108.1	31,597.7	53,949.6	105,649.2	474,108.2	386,178.5	387,603.2	387,308.7	323,655.2	290,975.7
2.1 Хөрөнгийн хувьцаа	23,746.4	27,246.1	49,346.3	100,934.1	464,918.9	377,002.9	378,262.5	378,765.2	300,093.4	265,818.4
2.1.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.3 Банкууд	3.3	3.1	3.2	18.9	18.8	18.9	19.0	19.1	19.1	19.0
2.1.4 Бусад салбар	23,743.2	27,243.0	49,343.1	100,915.2	464,900.1	376,984.0	378,243.5	378,746.1	300,074.3	265,799.4
2.2 Өрийн бичиг	4,361.7	4,351.6	4,603.3	4,715.1	9,189.2	9,175.6	9,340.7	8,543.6	23,561.9	25,157.3
2.2.1 Бонд, үнэт цаас	223.3	254.3	263.5	324.8	4,696.7	4,471.8	4,417.5	152.4	140.3	1,594.5
2.2.1.1 Төвбанк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.1.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.1.3 Банкууд	170.3	152.2	161.5	164.0	4,535.9	4,471.8	4,417.5	152.4	140.3	147.5
2.2.1.4 Бусад салбар	53.0	102.1	102.1	160.8	160.8	0.0	0.0	0.0	0.0	1,446.9
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	4,138.4	4,097.3	4,339.7	4,390.3	4,492.5	4,703.8	4,923.2	8,391.2	23,421.5	23,562.8
2.2.2.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.3 Банкууд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.4 Бусад салбар	4,138.4	4,097.3	4,339.7	4,390.3	4,492.5	4,703.8	4,923.2	8,391.2	23,421.5	23,562.8
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	434.8	462.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	4,962.4	4,928.3
3.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.3 Банкууд	434.8	462.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	4,962.4	4,928.3
3.4 Бусад салбар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4. Бусад хөрөнгө оруулалт	1,049,916.6	1,050,655.8	1,078,442.6	956,957.3	1,082,638.9	939,841.4	1,182,502.2	1,112,019.8	1,379,458.0	1,256,795.7
4.1 Худалдааны зээллэг	289,455.0	348,797.3	397,928.9	383,537.2	439,441.2	426,775.3	531,200.1	539,827.5	685,392.0	572,079.4
4.1.1 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.2 Бусад салбар	289,455.0	348,797.3	397,928.9	383,537.2	439,441.2	426,775.3	531,200.1	539,827.5	685,392.0	572,079.4
Урт хугацааны	12,516.4	31,820.3	101,633.6	54,221.3	41,638.0	28,790.8	24,157.4	5,418.6	10,608.5	7,828.5
Богино хугацааны	276,938.6	316,977.0	296,295.3	329,315.9	397,803.1	397,984.5	507,042.6	534,408.8	674,783.5	564,250.9
4.2 Зээл	21,602.7	21,666.1	20,879.6	14,958.5	15,322.3	17,641.7	17,168.3	4,780.6	4,874.0	6,337.1
4.2.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.3 Банкууд	21,602.7	21,666.1	20,854.4	14,933.3	14,763.1	14,455.0	13,383.5	1,990.8	1,847.3	4,054.6
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	21,602.7	21,666.1	20,854.4	14,933.3	14,763.1	14,455.0	13,383.5	1,990.8	1,847.3	4,054.6
4.2.4 Бусад салбар	0.0	0.0	25.2	25.2	559.2	3,186.7	3,784.9	2,789.8	3,026.7	2,282.5
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	25.2	25.2	559.2	3,186.7	3,784.9	2,789.8	3,026.7	2,282.5
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	738,858.9	680,192.4	659,634.1	558,461.6	627,875.4	495,424.3	634,133.7	567,411.7	689,192.0	678,379.2
4.3.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.3.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.3.3 Банкууд	457,280.0	502,934.8	396,357.1	529,650.0	475,116.9	457,815.0	521,883.8	494,244.2	572,082.6	498,713.2
4.3.4 Бусад салбар	281,578.9	177,257.7	263,277.0	28,811.6	152,758.5	37,609.3	112,250.0	73,167.6	117,109.5	179,666.1
4.4 Бусад актив	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.3 Банкууд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.4 Бусад салбар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
5. Нөөц актив	2,904,610.1	2,908,163.9	2,903,758.4	4,126,052.2	3,796,561.1	3,107,472.9	2,679,631.7	2,248,009.6	1,943,310.4	1,317,544.1

Үргэлжлэл.

Үзүүлэлт	3/31/2012	6/30/2012	9/30/2012	12/31/2012	3/31/2013	6/30/2013	9/30/2013	12/31/2013	3/31/2014	6/30/2014
II. Гадаад пассив	15,415,891.5	16,359,867.4	17,904,109.2	20,599,466.4	21,423,460.2	22,394,696.7	23,203,665.7	23,861,851.1	24,775,333.3	25,921,582.8
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	10,763,388.2	11,635,888.5	12,771,372.7	13,458,243.2	14,017,202.6	14,733,891.9	15,277,630.9	15,729,156.3	16,021,553.4	16,677,449.5
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	4,153,114.9	4,575,368.9	4,779,855.4	5,100,860.7	4,984,207.6	4,903,819.3	5,248,316.3	5,388,206.0	5,356,375.2	6,002,951.2
1.1.1 Хөрөнгө оруулагчаас авах	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.1.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	4,153,114.9	4,575,368.9	4,779,855.4	5,100,860.7	4,984,207.6	4,903,819.3	5,248,316.3	5,388,206.0	5,356,375.2	6,002,951.2
1.2 Бусад хөрөнгө	6,610,273.3	7,060,519.6	7,991,517.3	8,357,382.5	9,032,995.1	9,830,072.7	10,029,314.7	10,340,950.2	10,665,178.1	10,674,498.3
1.2.1 Хөрөнгө оруулагчаас авах	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.2.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	6,610,273.3	7,060,519.6	7,991,517.3	8,357,382.5	9,032,995.1	9,830,072.7	10,029,314.7	10,340,950.2	10,665,178.1	10,674,498.3
2. Багцын хөрөнгө оруулалт	910,689.4	931,858.2	1,204,288.0	2,689,392.0	2,683,280.6	2,665,211.7	2,648,279.9	2,470,242.8	2,872,240.3	2,876,135.2
2.1 Хөрөнгийн хувьцаа	95,012.5	103,603.3	102,349.8	112,925.6	101,893.0	97,358.3	86,030.7	34,806.8	89,085.2	86,856.0
2.1.1 Банкууд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.2 Бусад салбар	95,012.5	103,603.3	102,349.8	112,925.6	101,893.0	97,358.3	86,030.7	34,806.8	89,085.2	86,856.0
2.2 Өрийн бичиг	815,676.9	828,254.9	1,101,938.1	2,576,466.4	2,581,387.6	2,567,853.4	2,562,249.2	2,435,435.9	2,783,155.1	2,789,279.2
2.2.1 Бонд, үнэт цаас	815,676.9	828,254.9	1,101,938.1	2,576,466.4	2,581,387.6	2,567,853.4	2,562,249.2	2,435,435.9	2,783,155.1	2,789,279.2
2.2.1.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.1.2 Засгийн газар	618,654.5	619,422.1	600,357.8	2,080,024.6	2,080,024.3	2,080,023.7	2,080,021.2	2,080,019.2	2,316,717.0	2,316,717.0
2.2.1.3 Банкууд	195,912.8	207,636.5	500,384.1	495,269.8	500,845.2	483,772.9	478,171.2	351,360.0	462,381.4	462,965.3
2.2.1.4 Бусад салбар	1,109.6	1,196.2	1,196.2	1,171.9	518.0	4,056.8	4,056.8	4,056.8	4,056.8	9,596.9
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.3 Банкууд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.4 Бусад салбар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	435.0	462.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	4,987.0	4,868.4
3.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.3 Банкууд	435.0	462.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	4,987.0	4,868.4
3.4 Бусад салбар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4. Бусад хөрөнгө оруулалт	3,741,379.0	3,791,658.1	3,928,448.6	4,451,831.2	4,722,977.0	4,995,593.1	5,277,754.9	5,662,452.1	5,876,552.6	6,363,129.7
4.1 Худалдааны зээллэг	220,144.3	277,187.4	201,889.7	252,088.3	486,024.9	424,783.9	472,344.9	511,435.1	587,465.6	548,775.8
4.1.1 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.2 Бусад салбар	220,144.3	277,187.4	201,889.7	252,088.3	486,024.9	424,783.9	472,344.9	511,435.1	587,465.6	548,775.8
Урт хугацааны	49,035.3	62,494.3	52,728.2	31,437.8	229,774.3	247,064.2	280,158.3	338,909.6	358,128.4	331,860.6
Богино хугацааны	171,108.9	214,693.1	149,161.5	220,650.5	256,250.6	177,719.7	192,186.6	172,525.5	229,337.2	216,915.2
4.2 Зээл	3,341,530.1	3,310,210.9	3,326,684.4	3,621,480.5	3,627,305.7	3,850,651.7	4,086,909.7	4,427,058.3	4,572,476.0	4,551,754.3
4.2.1 Төв банк	268,870.3	264,461.2	251,876.1	77,860.3	74,389.6	74,675.2	74,818.6	75,482.5	75,336.7	75,273.0
ОУВС-гийн зээл	268,593.8	264,190.9	251,605.8	77,581.0	74,258.2	74,543.3	74,701.8	75,339.9	75,336.7	75,273.0
Бусад урт хугацааны	276.5	270.3	270.3	279.2	131.4	131.9	116.7	142.7	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.2 Засгийн газар	1,913,729.3	1,891,810.1	1,977,848.4	2,184,098.6	2,068,361.6	2,132,059.2	2,157,112.1	2,184,302.6	2,188,058.4	2,171,997.5
Урт хугацааны	1,913,729.3	1,891,810.1	1,977,848.4	2,184,098.6	2,068,361.6	2,132,059.2	2,157,112.1	2,184,302.6	2,188,058.4	2,171,997.5
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.3 Банкууд	253,412.9	291,299.3	278,966.6	336,817.0	336,775.9	415,504.4	442,703.7	629,390.8	680,123.1	698,005.9
Урт хугацааны	176,772.5	199,576.2	191,393.8	278,589.7	277,402.9	354,169.1	360,776.7	429,226.9	481,822.5	483,432.7
Богино хугацааны	76,640.4	91,723.1	87,572.9	58,227.3	59,373.0	61,335.3	81,927.0	200,164.0	198,300.6	214,573.1
4.4.4 Бусад салбар	905,517.6	862,640.4	817,993.3	1,022,704.6	1,147,778.6	1,228,412.9	1,412,275.4	1,537,882.4	1,628,957.8	1,606,477.9
Урт хугацааны	477,558.4	464,959.6	428,661.0	735,122.7	851,568.8	948,836.1	1,135,439.7	1,304,696.2	1,403,785.3	1,366,396.4
Богино хугацааны	427,959.2	397,680.8	389,332.3	287,581.9	296,209.8	279,576.8	276,835.7	233,186.2	225,172.5	240,081.5
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	85,704.6	110,259.9	96,951.2	142,271.5	172,822.5	202,586.9	168,929.8	160,388.2	153,040.5	135,553.4
4.3.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.3.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.3.3 Банкууд	85,704.6	110,259.9	96,951.2	142,271.5	172,822.5	202,586.9	168,929.8	160,388.2	153,040.5	135,553.4
4.3.4 Бусад салбар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4 Бусад пассив	94,000.0	94,000.0	302,923.2	435,991.0	436,823.8	517,570.5	549,570.5	563,570.5	563,570.5	1,127,046.2
4.4.1 Төв банк	0.0	0.0	208,923.2	335,991.0	315,823.8	406,570.5	406,570.5	406,570.5	406,570.5	965,046.2
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	208,923.2	335,991.0	315,823.8	406,570.5	406,570.5	406,570.5	406,570.5	965,046.2
4.4.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.3 Банкууд	94,000.0	94,000.0	94,000.0	100,000.0	121,000.0	111,000.0	143,000.0	157,000.0	157,000.0	162,000.0
Урт хугацааны	94,000.0	94,000.0	94,000.0	100,000.0	121,000.0	111,000.0	143,000.0	157,000.0	157,000.0	162,000.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.4 Бусад салбар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (мянган ам.доллар)

	2012.Q1	2012.Q2	2012.Q3	2012.Q4	2013.Q1	2013.Q2	2013.Q3	2013.Q4	2014.Q1	2014.Q2
Засгийн газар	2,532,384	2,511,232	2,578,206	4,264,123	4,148,386	4,212,083	4,237,133	4,264,322	4,504,775	4,488,714
Богино хугацаат	-	-	-	-	-	-	-	-	-	-
Харилцах, хадгаламж 5/										
Өрийн бичиг 4/										
Зээл										
Худалдааны зээл болон урьдчилгаа										
Бусад өглөг 6/										
Урт хугацаат	2,532,384	2,511,232	2,578,206	4,264,123	4,148,386	4,212,083	4,237,133	4,264,322	4,504,775	4,488,714
Зээлжих тусгай эрх (ЗТЭ), Хуваарилалт 7/										
Харилцах, хадгаламж 5/										
Өрийн бичиг 4/	618,654	619,422	600,358	2,080,025	2,080,024	2,080,024	2,080,021	2,080,019	2,316,717	2,316,717
Зээл	1,913,729	1,891,810	1,977,848	2,184,099	2,068,362	2,132,059	2,157,112	2,184,303	2,188,058	2,171,998
Худалдааны зээл болон урьдчилгаа										
Бусад өглөг 6/										
Төвбанк	670,106	264,461	460,810	413,851	390,213	481,246	891,774	1,065,314	1,041,980	1,040,319
Богино хугацаат	401,235	-	208,923	335,991	315,824	406,571	816,955	989,831	966,643	965,046
Харилцах, хадгаламж 5/										
Өрийн бичиг 4/										
Зээл										
Худалдааны зээл болон урьдчилгаа										
Бусад өглөг 6/	401,235	-	208,923	335,991	315,824	406,571	816,955	989,831	966,643	965,046
Урт хугацаат	268,870	264,461	251,887	77,860	74,390	74,675	74,819	75,483	75,337	75,273
Зээлжих тусгай эрх (ЗТЭ), Хуваарилалт 7/	75,333	74,098	75,057	75,074	73,039	73,319	74,702	75,340	75,337	75,273
Харилцах, хадгаламж 5/										
Өрийн бичиг 4/										
Зээл	193,537	190,363	176,830	2,786	1,351	1,356	117	143	0	-
Худалдааны зээл болон урьдчилгаа										
Бусад өглөг 6/										
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	629,030	703,196	970,302	1,074,358	1,131,444	1,212,864	1,232,805	1,298,139	1,452,545	1,458,525
Богино хугацаат	76,640	91,723	87,573	58,227	59,373	61,335	81,927	200,164	198,301	214,573
Харилцах, хадгаламж 5/										
Өрийн бичиг 4/										
Зээл	76,640	91,723	87,573	58,227	59,373	61,335	81,927	200,164	198,301	214,573
Худалдааны зээл болон урьдчилгаа										
Бусад өглөг 6/										
Урт хугацаат	552,390	611,473	882,729	1,016,131	1,072,071	1,151,529	1,150,878	1,097,975	1,254,244	1,243,951
Харилцах, хадгаламж 5/	85,705	110,260	96,951	142,272	172,823	202,587	168,930	160,388	153,041	135,553
Өрийн бичиг 4/	195,913	207,637	500,384	495,270	500,845	483,773	478,171	351,360	462,381	462,965
Зээл	176,773	199,576	191,394	278,590	277,403	354,169	360,777	429,227	481,823	483,433
Худалдааны зээл болон урьдчилгаа										
Бусад өглөг 6/	94,000	94,000	94,000	100,000	121,000	111,000	143,000	157,000	157,000	162,000
Бусад салбарууд	1,125,662	1,139,828	1,019,883	1,274,793	1,633,804	1,653,197	1,884,620	2,049,318	2,216,423	2,164,851
Богино хугацаат	599,068	612,374	538,494	508,232	552,460	457,297	469,022	405,712	454,510	456,997
Харилцах, хадгаламж 5/										
Өрийн бичиг 4/										
Зээл	427,959	397,681	389,332	287,582	296,210	279,577	276,836	233,186	225,172	240,082
Худалдааны зээл болон урьдчилгаа	171,109	214,693	149,162	220,651	256,251	177,720	192,187	172,526	229,337	216,915
Бусад өглөг 6/										
Урт хугацаат	526,594	527,454	481,389	766,561	1,081,343	1,195,900	1,415,598	1,643,606	1,761,914	1,707,854
Харилцах, хадгаламж 5/										
Өрийн бичиг 4/										9,597
Зээл	477,558	464,960	428,661	735,123	851,569	948,836	1,135,440	1,304,696	1,403,785	1,366,396
Худалдааны зээл болон урьдчилгаа	49,035	62,494	52,728	31,438	229,774	247,064	280,158	338,910	358,128	331,861
Бусад өглөг 6/										
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	6,610,273	7,060,520	7,991,517	8,357,382	9,032,995	9,830,073	10,029,315	10,340,950	10,665,178	10,674,498
Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг	6,610,273	7,060,520	7,991,517	8,357,382	9,032,995	9,830,073	10,029,315	10,340,950	10,665,178	10,674,498
Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг										
Хамааралтай компани хоорондын өглөг										
Нийт гадаад өр	11,567,455	11,679,236	13,020,718	15,384,508	16,336,842	17,389,462	18,275,646	19,018,042	19,880,902	19,826,907